

Огноо 2022/07/20

№ 22/05

Улаанбаатар

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60, 61,-р заалт, 64.2 дахь заалт, 65.1, 65.4 дэх заалт, 71.3, 71.4 дэх заалт, 76.1.2, 76.1.3- дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам, болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 7-р сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтнер Лэнд Групп” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 8-р сарын 30-ны 12:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, Пума Империл зочид буудлын хурлын бага танхимд хуралдах танхимаар хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2022 оны 8-р сарын 12-ний өдрөөр тогтоосугай
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалтыг тогтоолын Хавсралт 1-р баталсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2022 оны 7-р сарын 29-ны дотор бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компаниудад хүргүүлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 2-р баталж, 2022 оны 7-р сарын 25 болон 2022 оны 8-р сарын 9-ний өдрүүдэд тус тус Санхүүгийн Зохицуулах хорооноос гаргасан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам-д заасны дагуу олон нийтэд зарласугай
6. Хурлын хэлэлцэх асуудлуудтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалтыг тогтоолын Хавсралт 3-р, санал авах хуудасны агуулга, загварыг тогтоолын Хавсралт 4-р, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэгийг тогтоолын Хавсралт 5-р тус тус баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн хугацааг 2022 оны 8-р сарын 30-ний өдрийн 10:00 цагаар тасалбар болгосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдэлийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2022 оны 7-р сарын 22-ны дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлсүгэй
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Э.Тэмүүллинг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга: Э.Пүрэвдулам

Гишүүн: А.Амирлан

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга: Р.Сайдаброр

Гишүүн: У.Анар

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Э.ТЭМҮҮЛИН